## СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР
## ТЭТГЭВЭР ТЭТГЭМЖИЙН ХЭЛТЭС

### 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| ***Зорилт 1:*** *"Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1: Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах; | Шаардлага гүй | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан 4 хууль, холбоотой 40 дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвл өмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:<br>- ЗГ-ын тогтоол-15<br>- НДҮЗ тогтоол-7<br>- ХНХын сайдын тушаал-10<br>- ХНХС, ЭМС хамтарсан -4<br>- ХНХС, ГХС хамтарсан -1 | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан 4 хууль, холбоотой дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:<br>- Засгийн газрын тогтоол-1<br>- БХС, ГБХНХС хамтарсан -1<br>- НДЕГ-н–зөвлөмж чиглэл-12<br>- ЭММТЗ-н зөвлөмж чиглэл - 10<br>Шинэчилсэн багц хуулийн талаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагад 4 удаа, ажилтан, албан хаагчдад 2 удаа төрөлжсөн сургалтуудыг зохион | 100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | - ХНХС,СангийнСайдын хамтарсан -1<br>- НДЕГ-ын -2<br>Шинэчилсэн багц хуулийн талаар иргэд, аж ахуйн нэгж байгууллага, ажилтан, албан хаагчдад төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулсан | | байгуулсан. Хууль дүрэм журмыг хэрэгжүүлж, 2025 оны эхний хагас жилд МНБИтэй хамтран ажиллах 1 жилийн гэрээ байгуулан ажиллаж байна. | |
| 2 | Арга хэмжээ 1.4: Ажил олгогч, иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, үр дүнг хагас жил тутам Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх; | Шаардлага гүй | Авсан судалгааны тоо | - | Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн сэтгэл ханамжийг 1-5 оноогоор дүгнэж, судалгааны үр дүнг албан бичгээр 6 дугаар сарын 10, 12 сарын 10-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газар хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгалын үйлчилгээ авсан 193 иргэнээс 15 асуултаар сэтгэл ханамжийн судалгаа авч судалгааны үр дүнд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн. | 100 % |
| ***Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| ***Зорилт 2:** “Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт,чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, өр барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мөнгөжүүлсэн орлогыг тэтгэврийн нөөц санд байршуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах” **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 3 | Арга хэмжээ 2.2: Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах. | | Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад 282,39 тэрбум төгрөгийн тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг | а. Тэтгэврийн даатгалын сангаас олгох 3 төрлийн тэтгэврийг сар бүрийн 1-нд хугацаанд нь олгож байна. 2024 онд сар бүр дунджаар 23797 тэтгэвэр авагчдын 20,1 тэрбум төгрөгийн тэтгэврийн тооцоог хийж нийтдээ 241,3 тэрбум төгрөг олгосон байна. | а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох<br>б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу 240,8 тэрбум төгрөгийн | а. 2025 оны эхний хагас жилд 138,58 тэрбум төгрөгийн тэтгэврийг тэтгэврийн даатгалын сангаас зарцуулах төлөвлөгөөтэйгээс 137,1 тэрбум төгрөгийн тэтгэврийг олгож батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлэлгүй ажилласан байна. Сар бүр дунджаар 24730 тэтгэвэр авагчдын 22,8 тэрбум төгрөгийн тэтгэврийн тооцоог хийж, олгосон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хугацаанд нь олгоно. | б. Нийгмийн даатгалын сангийн батлагдсан зардлыг хэтрүүлэлгүй сар бүр хугацаанд нь олгож ажилласан. 2024 оны ХБГ-р 23797 тэтгэвэр авагчид нийтдээ өссөн дүнгээр 241,3 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 15878 тэтгэмж авагчид 27,8 тэрбум төгрөгийн тэтгэмж тус тус олгосон байна | тэтгэвэр, 29,01 тэрбум төгрөгийн тэтгэмж хуульд заасан хугацаанд зарцуулсан байна. | б. Тус хэлтэс нь 2025 оны эхний хагас жилд 6 төрлийн тэтгэмжид нийтдээ 14,6 тэрбум төгрөгийн тэтгэмж олгох төлөвлөгөөтэйгээс 9637 даатгуулагчдад 12,1 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон. Үүнд: Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 7352 даатгуулагчдад 2,1 тэрбум төгрөг, Жирэмсэн амаржсаны тэтгэмжид 861 даатгуулагчдад 3,7 тэрбум төгрөг, Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжид 307 даатгуулагчдад 524,0 сая төгрөг, Ажилгүйдлийн тэтгэмжид 1002 даатгуулагчдад 5,3 тэрбум төгрөг<br>Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 115 даатгуулагчдад 212,1 сая төгрөгийн тэтгэмж, төлбөр бодож олгосон | |
| 4 | Арга хэмжээ 2.7: Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх. | | Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн НДЕГ-т хүргүүлнэ. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан. | а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. 5 банкинд тэтгэвэр олголтын файлыг сар бүрийн эхний өдөр хүргүүлж, сарын дундуур жагсаалтаар тэтгэврийн сунгалт, өөрчлөлт хийсэн файлыг хүргүүлэн, Банкуудтай ажиллах гэрээний заалтуудыг чанд мөрдөн ажиллаж байна. | 100% |
| | Арга хэмжээ 2.8: Нийгмийн даатгалын сангийн цахим | | Холбогдох хууль тогтоомжийн дагуу | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг | а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь | Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх. | | мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ. | тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн. | үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх. | залруулга гаргахгүй ажилласан. Сикос системээр тэтгэвэр ба тэтгэмжийн тайланг гаргах үүрэг НДЕГ-с өгсний дагуу 2025 оны 01 дүгээр сараас тэтгэвэр ба тэтгэмж авагчдын Хүсэлт шалгах, Хуваарь үүсгэх, засах, шалгах, Нэхэмжлэл олголт үүсгэн, хаалт хийж, Нягтлан бодогчид хүлээлгэн өгч Тэтгэвэр ба тэтгэмжийн тайланг шинэ системээр гаргасан. | |
| 6 | Арга хэмжээ 2.9: Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх" төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх. | | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ.. | Нийгмийн даатгалын сангийн "Core" системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажиллаж байна. 2024 онд коре системд 2 удаа сайжруулалтын санал хүргүүлж, 60 удаагийн алдаа засуулах хүсэлт Жира системд бүртгэж, засуулж ажилласан. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | Нийгмийн даатгалын сангийн шинэ системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажиллаж байна. 2024 оны жилийн эцсийн тайланг шинэ системээр эцэслэн гаргахын тулд системийн сайжруулалтын санал тухай бүр хүргүүлж, жилийн эцсийн тайланг шинэ системээр гаргасан. Системийн алдаа засуулах 95 хүсэлтийг Жира системд тухай бүр бүртгэж, МТТ-р алдааг засуулж ажилласан. | 100% |
| **Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт** | | | | | | | |
| ***Зорилт 4:*** *"Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 7 | Арга хэмжээ 4.1: Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, | | Өгсөн үүрэг даал-гаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлж, хариуг | Нийгмийн даатгалын багц хуулиуд, Засгийн газрын 15 тогтоол, ЗГХЭГ-ын 1 тушаал, ХНХСайдын 10 тушаал, ХНХ сайдын хамтарсан 6 тушаал, НДҮЗ-ийн 7 тогтоол, НДЕГ-ын даргын 2 тушаал, | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт | Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан 4 хууль, холбоотой дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тайлан, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх; | | хугацаанд нь хүргүүлэх; | Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 17, СБДЗД-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 17 арга хэмжээний биелэлтийг хангаж ажилласан. | хангагдсан байна. | - Засгийн газрын тогтоол-1<br>- БХС, ГБХНХС хамтарсан -1<br>- НДЕГ-н–зөвлөмж чиглэл-12<br>- ЭММТЗ-н зөвлөмж чиглэл - 10<br>Заавар журам зөвлөмж чиглэлийг тухай бүр ажилтнуудад танилцуулан хэрэгжүүлэн биелэлтийг хангаж ажилласан. | |
| 8 | Арга хэмжээ 4.2: Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах; | | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | Даатгуулагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж буй байдлыг түргэн шуурхай зохион байгуулан ажиллаж байна. 2024 онд тус хэлтэстэй холбоотой нийт 79 албан бичиг ирснээс бүрэн шийдвэрлэж, шийдвэрлэлтийн хувь 100%-тай байна. UB ERP програмаар, 3Гын 11-11төв, НДЕГ-с өргөдөл, гомдол, хүсэлт 89 ирснээс хугацаанд нь бүрэн шийдвэрлэж ажилласан байна. | Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Даатгуулагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилд тус хэлтэстэй холбоотой нийт 43 албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлт ирснийг хугацаанд нь бүрэн шийдвэрлэж, шийдвэрлэлтийн хувь 100%-тай байна. UB ERP програм, 3Гын 11-11төв, НДЕГ-с өргөдөл, гомдол, хүсэлт 22 ирснийг хугацаанд нь бүрэн шийдвэрлэж ажилласан байна. | 100% |
| 9 | Арга хэмжээ 4.8: Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлж ажиллах; | | Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлсэн байна | - | Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлсэн байна | 2025 оны эхний хагас жилд дээд газраас өгсөн хугацаатай үүрэг даалгавруудыг тухай бүр хугацаанд нь тогтмол хүргүүлсэн. Үүнд:<br>-2024 оны жилийн эцсийн болон 2025 оны 1-р улирлын тэтгэмжийн тайлан шинэ системээр гаргах<br>-2024 оны жилийн эцсийн болон 2025 оны 1-р улирлын тэтгэврийн тайланг шинэ системээр гаргах | 100% |

***Зорилт 4.1:*** *"Нийгмийн даатгалын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, байцаагч, ажилтныг чадавхжуулах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургалтыг системтэй, мэргэжлийн түвшинд байнга тасралтгүй явуулах, нөгөө талаар ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын талаарх хууль эрх зүйн мэдлэг олгох хичээл сургалтыг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:***

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Арга хэмжээ 4.1.1: Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх | | -Авлигаас урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалт зохион байгуулах,<br>-Нийт албан хаагчдыг 100% хамруулсан байна. | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 2 удаа зохион байгуулсан. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | Хэлтсийн төрийн болон үйлчилгээний албан хаагчдад Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн газраас Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтаар ашиг сонирхлын зөрчил болон хувийн, нийтийн ашиг сонирхлын талаар, авлигын тухай ойлголт, албан хаагчдын хуулиар хориглох үйлдэл, хариуцлага хүлээлгэх үндэслэл зэргийн талаар ойлголтыг авч ажилтан, албан хаагчид хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. | 50% |
| ***Зорилт 4.2:** “Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 11 | Арга хэмжээ 4.2.1: Нийгмийн даатгалын байгууллагад хэрэгжүүлж буй ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах; | | НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн “Нийгмийн даатгалын байгуул-лагын байцаагч (ажилтан)–ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам” батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн | 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус газрын орон тоо, бүтцийн өөрчлөлтөөр тус хэлтсийн харьяанд Нэг цэгийн үйлчилгээний тасаг байгуулагдан, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын бүх төрлийн үйлчилгээ, зөвлөгөө үзүүлэх чиг үүрэг тасаг ажиллаж эхлээд байна.<br>Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулж, ажлын байр, | Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулж, ажлын байр, үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Тус хэлтсийн харьяанд Нэг цэгийн үйлчилгээний тасаг 8 ажилтантай байгуулагдан, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын бүх төрлийн үйлчилгээ, зөвлөгөө үзүүлэх чиг үүрэг тасаг ажиллаж эхлээд байна. Иргэдэд үзүүлэх зөвлөгөө мэдээллийг нэг цэгээс үзүүлснээр иргэдийн сэтгэл ханамж сайжирч гомдол эрс буурсан. 2024 оны эхний хагас жилд иргэдээс 50 гомдол санал хүсэлт ирж байсан бол 2025 оны эхний хагас жилд 22 болж, өнгөрсөн жилийн мөн үеэс иргэдийн гомдол 50 хувиар буурсан байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | “Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)–ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт” батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг мөрдөж ажилласан байна | үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | | Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулж, ажлын байр, үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |
| 12 | Арга хэмжээ 4.2.2: Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах; | | Дуудлага алдалт 15%-аас хэтрүүлэхгүй ажилласан байна | Ирсэн дуудлага 26669, дуудлага алдалт дунджаар 23 % байна. | Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч, ажилласан байна. | Газрын хэмжээнд CallPro үйлчилгээний дуудлага алдалтыг багасгах зорилгоор ажилтнуудаас санал авсны үндсэн дээр дотооддоо шинэ журам батлан, бүх ажилтнуудыг хамруулан 7 хоног бүр шинэ хуваарь гарган ажилласнаар дуудлага алдалт байхгүй болсон. | 100% |
| 13 | Арга хэмжээ 4.2.6: 2024 онд эхэлсэн тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулах ажлыг бүрэн дуусгах; | | Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолт оор заагдсан чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. | Тус хэлтэс 2024 онд хийх шинэлэг ажилд Цахим монгол-Цахим архивын хүрээнд архиваа стандартын дагуу тохижуулж, чип суулгаж цахимжуулах ажил төлөвлөж хэрэгжүүлсэн байна. Дүүргээс Цахим архив төслийг санхүүжүүлснээр идэвхитэй тэтгэврийн 23192 тэтгэврийн цахим архивыг бий болгож архивын баримтуудыг тоолох бүртгэх | Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Тус хэлтэс нь 2024 онд санаачилж хэрэгжүүлсэн Цахим монгол-Цахим архивын хүрээнд архиваа стандартын дагуу тохижуулж, чип суулгаж цахимжуулах ажил төлөвлөж хэрэгжүүлсэн байна. Дүүргээс Цахим архив төслийг санхүүжүүлснээр идэвхитэй тэтгэврийн 23192 тэтгэврийн цахим архивыг бий болгож архивын баримтуудыг тоолох бүртгэх мэдээллийг цахимжуулах ажлыг бүрэн гүйцэтгэсэн.<br>2025 онд 1-7 дугаар хорооны 7558 тэтгэврийн идэвхитэй хувийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэдээллийг цахимжуулах ажлыг бүрэн гүйцэтгэсэн. Тэтгэврийн хувийн хэргийн хайрцгийг 1 стандартад оруулан идэвхитэй болон зогсоогдсон нийт 1911 хайрцгийг хаягжуулсан. Архивт 1 өрөө нэмж гарган өөрсдийн хүчээр засвар хийж будаж тохижуулсан. Шинээр нэмж 9ш тавиуруудыг байрлуулан архиваа төрөлжүүлсэн. | | хэргүүдийг бүрэн скайнердаж архивын шинээр нэвтрүүлсэн програмдаа холбож цахимжуулсан. 2025 онд үлдсэн 8-20 дугаар хороодын хувийн хэргийг цахимжуулах зорилт тавин ажиллаж байна. | |
| ***Зорилт 4.3:** “Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эрүүл мэндийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх” **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 14 | Арга хэмжээ 4.3.1: Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр ижил мэргэжилтний үзлэг зохион байгуулж, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд тавих дотоодын хяналтыг эрчимжүүлж ажилласан байх; | | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад жилд 4-өөс доошгүй удаа хяналт хийсэн байна. | МУ-ын Засгийн газрын 2023 оны 448-р тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийн дагуу тус дүүргийн ЭММЗ-ийг 10 гишүүний бүрэлдхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, нийт 20 удаа хуралдаж, 849 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлээд байна, үүнээс 594 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, жагсаалтын шаардлагад нийцсэн 173 иргэнд өвчний явц, шинжилгээ, үзлэг, өвчтөнд илэрч буй зовиур өөрчлөлтийг үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоож, биеийн байдал сайжирсан, эдгэрсэн, хяналтын хугацаа дууссан шалтгаанаар 66 | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад хяналт хийж холбогдох арга хэмжээ авсан байна. | Тус газрын дэргэдэх эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн санд оны эхний өдрийн байдлаар 3297 иргэний мэдээллийг хадгалж байна. Тайлант хугацаанд 2 удаа халамжийн болон нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн төвийн E-Health программтай нас барсан иргэдийн мэдээллийг тулган шалгах, нийгмийн даатгалын системд хугацаагүй хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн мэдээлэл татагдахгүй байгаа, шилжиж ирсэн, шилжиж явсан иргэдийн шилжилт хөдөлгөөнийг хийх зорилгоор мэдээллийн санд нас барсан 32, мэдээлэл шинэчилсэн 30, шилжиж ирсэн 26, шилжин явсан 28, нийт 116 хүний мэдээллийг улиралд 1 удаа, нийт 2 удаа үнэн зөв засварлаж, шинэчлэв. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | иргэний хувь, хугацааг цуцлаад байна. | | | |
| 15 | Арга хэмжээ 4.3.2: Орон нутгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, бууруулах, эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн эмх цэгцийг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байх; | | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг хагас жил тутам зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | Эрүүл мэндийн магадлалын цахим мэдээллийн сангийн бүрдэлд улирал бүр хяналт хийж, даатгуулагчийн хувийн мэдээлэл зөрсөн байх магадлалтай, системийн шинэчлэл хийх бэлтгэл ажлын хүрээнд нийт 124 хүний мэдээллийг нягтлан шалгах ажлыг хийж дуусгав. Дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдсан нийт 3139 иргэний эмнэлгийн хувийн хэргийг төрөлжүүлж цэгцлэх, тухайн сард зөвлөлийн хурлаар орж хувь, хугацаа сунгуулах, зогсоох шийдвэр гаргуулах шаардлагатай иргэдийн жагсаалтыг урьдчилан гаргаж, өрхийн болон Эрүүл мэндийн төвийн нарийн мэргэжлийн эмч нарыг мэдээллээр хангаж ажилласны үр дүнд сунгалт хийлгэх хугацаа хэтэрсэн тохиолдол буурсан байна. | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | Тус дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь нийт 11 удаа хуралдаж, 465 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэсэн байна. Үүнээс Хөдөлмөрийн чадвар алдалтанд хүргэж байгаа шалтгаанд нүдний эмгэг, дотор, мэдрэл, гэмтэл согогийн өвчин, мэс заслын өвчин зонхилж байна.<br>Тахир дутуугийн тэтгэвэр авагчид 2024оны 1 улиралд нийгмийн даатгалын сангаас тэтгэврээ авдаг иргэд 65,6% байсан бол 2025 оны 1 улиралд 73% болж 7,4 хувиар өссөн байна.<br>Дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог хороо тус бүрээр ангилж гарган, мөн зонхилох хувь эзэлж байгаа өвчний эзэлж байгаа хувь, тооны мэдээллийг постер хэлбэрээр бэлтгэж, газрын пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэсэн. Энэ ажлын хүрээнд дүүргийн Эрүүл мэндийн төвийн нарийн мэргэжлийн болон өрхийн эмч нарт мэдээлэл хийж, иргэдийн нөхөн сэргээх чиглэлээр зөвлөмж өгч ажиллаж байна. | 100% |
| | | | | - | Иргэний эрүүл мэндийн анхан шатны баримт бичиг /амбулаторийн карт, рентгент зураг, CD8 DVD зэрэг/-ийн эмх цэгц, хадгалалт хамгаалалтыг | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа хэлэлцсэн 465 иргэний онош баталгаажуулсан шинжилгээний хариу, амбулаторийн картын бичилт, дүгнэлт зэргийг скайнердэж, мэдээллийн сан үүсгэн хадгалж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сайжруулах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллаж, үр дүнд хүрсэн байна. | | |
| 16 | Арга хэмжээ 4.3.3: Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль, тогтоомжийг танилцуулах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүд болон иргэдэд чиглэсэн сургалт зохион байгуулах; | | Сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо, тайлан | 2024 онд 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан | Эрүүл мэндийн магадлал болон эмнэлгийн хуудас бичилт олголттой холбоотой хууль тогтоомж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүдэд 1-2 удаагийн сургалт зохион байгуулсан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу МУ-ын Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм"-ийн талаар Эрүүл мэндийн төвийн нарийн мэргэжлийн болон өрхийн эмч нарт мэдээлэл өгөх сургалтыг 02 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд зохион байгуулж, дүүргийн Эрүүл мэндийн төв, Сэлбэ нэгдсэн эмнэлгийн эмнэлгийн хуудас бичих эрх бүхий эмч, дүн бүртгэлийн мэргэжилтнууд 45 хүнийг оролцуулав.<br>Тус дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд, хуралд танилцуулга хийхээр ирсэн нарийн мэргэжлийн болон өрхийн эмч нар, нийт 19 хүнд зориулж 02 дугаар сарын 12-ны өдрийн хурлын эхэнд мөн дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарах асуудлын талаар товч мэдээлэл хийв.<br>ЭММТЗөвлөлөөс 2025-05-28-ны өдөр авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан 1 цагийн сургалтанд тус зөвлөлийн дарга, гишүүн8 хүнийг танхимаар, 1 эмчийг цахимаар оролцуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Арга хэмжээ 4.3.4: Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах; | | Хэрэгжүүлсэн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөмжийн тоо | 2024 онд 5 үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, эрүүл мэндийн магадлалын чиглэлээр 4 судалгаа хийж тайланг Төв зөвлөлд хүргүүлэн ажилласан. | Дээд газраас өгсөн чиглэл, зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажилласан байна. | Тайлант хугацаанд эмнэлгийн хуудас хянах, эрүүл мэндийн магадлалын чиглэлээр НДЕГ-ын дэргэдэх ЭММТЗөвлөлөөс өгсөн 6 удаагийн үүрэг даалгаврын дагуу 1-р улирлын байдлаар биелэлтийг гаргаж, заасан хугацаанд нь хүргүүлээд байна. | |
| ***Зорилт 4.4:*** *"Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 18 | Арга хэмжээ 4.4.3: Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах; | | Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангасан байна. | - | Програм хангамжуудын эрхийн тохиргооны дагуу зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна. | Газрын мэдээллийн технологийн мэргэжилтний олгосон эрхийн дагуу нийгмийн даатгалын sicos.mndaatgal.mn системд нэвтрэх эрх, нууц үгийг ашиглан нэвтэрч ажилладаг, мөн ажлын чиг үүргийн дагуу бусад программ хангамж болон өөрийн эзэмшдэг компьютерт тусгай нууц үгийг ашиглаж хэвшсэн. | 100% |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* ***Төсвийн шууд захирагч***

ГАЗРЫН ДАРГА ........................................ /Б.ЭНХТӨР/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(огноо*

Тэмдэг 2025.06.17

*Тайлагнасан:* ***Нэгжийн дарга***

ХЭЛТСИЙН ДАРГА ........................................ /Ч.ЭРДЭНЭЧИМЭГ/ 2025.06.10

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(огноо)* ..............................